

## **Стивен Барнетт: Баялаг бүтээгчид шахагдах нь хэт тэлсэн төсвийн бодлогын ХАРАМСАЛТАЙ ҮР ДАГАВАР**

Олон улсын валютын сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Стивен БАРНЕТТАЙ ярилцлаа.

**-ОУВС-гийнхан саяхан Монголын эдийн засгийн бодлогыг нэлээд онцолж, “хэт тэлсэн” байна гэж анхааруулсан. Ямар үзүүлэлтүүд, үндэслэлээр ингэж үзсэн бэ?**

-Төсвийн зарлага огцом өсч байгаа нь үндсэн шалтгаан болж байгаа юм. Нэгдсэн төсвийн зарлага энэ онд 67 хувиар өссөн бол 2012 онд 2010 оны төвшнөөс даруй хоёр дахин их болох гэж байна. Төсвийн зарлага энэ богино хугацаанд хоёр дахин өсч байгааг бид “хэт тэлсэн” гэж хэлж байгаа юм. Зарлага ингэж их хэмжээгээр нэмэгдсэнээр макро эдийн засгийн тогтвортой байдал алдагдаж, үнийн өсөлтийг хөөрөгдөнө. Энэ нь бага орлоготой иргэдэд илүү хүнд ачаа болно. Дээр нь Монгол Улсын эдийн засгийг дэлхийн эдийн засагт гарч болзошгүй цочролд өртөмтгий болгож байна. Ийм цочрол үүсэх эрсдэл яг одоо өндөр байна.

**-Бас бодлогын хүүг 0.5 пунктээр чангаруулсан ч эдийн засгийн халалт, инфляцыг барихад хангалтгүй гэж байсан. Дахин хэр хэмжээгээр нэмбэл хангалттай болно гэж үзэж байгаа вэ?**

-Төв банкнаас мөнгөний бодлогыг чангаруулах арга хэмжээ авсныг сайшаан дэмжиж байгаа. Цаашид нэмж арга хэмжээ авахыг ч хүлээж байна. Бодлогын хүүг өсгөхийн хажуугаар макро зохистой арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна. Жишээ нь, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг нэмэгдүүлэх, хөрвөх чадварын үзүүлэлтийг чангатгах, зээлийн алдагдлын сан байгуулах хувь хэмжээг өсгөх зэрэг арга хэмжээ авч болно. Энэ макро төвшний арга хэмжээнүүд зээлийн өсөлтийн хурдыг сааруулж, эдийн засагт уналт бий болоход банкны системийг хамгаалж авч үлдэхэд туслах учиртай. Нэг үгээр хэлбэл зохистой байдлыг хангаж байгаа юм. Он гарсаар банкны зээл эрс өссөн, тодруулбал 50 гаруй хувиар өсч, хэт халалтыг даамжруулж байгааг дурьдахгүй байж болохгүй. Цаашилбал, эдийн засаг тэлж байгаа энэ үед эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх арга хэмжээ авах цаг болсон.

**-Гэхдээ мөнгөний бодлогыг чангаруулахаар хэтдээ эдийн засагт бүхэлд нь сайнаар нөлөөлөх ч арилжааны банкуудын зээлийн хүү дахин өссөнөөр нийгмийн бага, дунд орлоготой хэсгийнхэнд, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд маш хүнд тусна. Үүнийг яаж зохицуулах боломжтой вэ?**

-Тантай зарим талаар санал нийлж байна. Инфляцын тухайд харин санал нийлэхгүй байна. Инфляц бодлогын хүүгийн өсөлтөөс илүү бага орлоготой иргэдэд хамгийн хүнд үр дагавар авчирдаг. Иймд мөнгөний бодлогын инфляцыг хазаарлах зорилгоор хийгдэж буй хумилт нь ядуусыг хамгаалахад тус болох ёстой.

Жижиг, дунд бизнесийн хувьд бол санал нийлж байна. Мөнгөний бодлого чангарснаар зээлийн хүү өсч, гол баялаг бүтээгчид болох жижиг, дунд бизнесийнхэн болон бусад зээлдэгчийг зах зээлээс шахан зайлуулна. Үнэндээ

мөнгөний бодлого халсан эдийн засгийг ингэж л хөргөдөг бөгөөд энэ нь хэт тэлсэн төсвийн бодлогын харамсалтай боловч зайлшгүй үр дагавар юм. Мөн төсвийн бодлого сул байсны үр дүнд хувийн хэвшил хэрхэн шахагддагийн тод жишээ юм.

Төсвийн зарлагыг нэлээд бага төвшинд байлгах нь хамаагүй дээр бодлогын хослол болно. Энэ нь эргээд үйл ажиллагаагаа банкны зээлээр санхүүжүүлэх орон зайг хувийн хэвшилд гаргаж өгнө.

**-Дэлхийн банк, ОУВС, Монголбанкны зөвлөснөөр УИХ ирэх оны төсвийг 1.1 их наядаар танаж баталсан байгаа. Таны бодлоор төсвийг энэ хэмжээгээр танасны үр дүнд инфляцыг 10 хувьд барих боломж бий болсон уу?**

-2012 оны нэгдсэн төсвийн зарлагын таналт нь хангалттай биш байна. Мэдээж зарлагыг тодорхой хэмжээгээр танасныг сайшаан дэмжиж байна. Энэ нь инфляцын дарамтыг бууруулахад тус дөхөм болох нь гарцаагүй. Гэхдээ эцсийн дүндээ төсвийн бодлого хэт тэлсэн хэвээрээ л үлдлээ. Нэгдсэн төсвийн зарлага 2012 онд 2010 оны төвшнээс хоёр дахин их байна. Үнэхээр их өсөлт. 2012 оны төсвийн талаар бидний өгсөн зөвлөмж бол УИХ-ын хаврын чуулганаар батлагдсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан 2012 оны зарлагын үзүүлэлтүүдийг хангах явдал байсан. Өөрөөр хэлбэл, нэгдсэн төсвийн зарлага 4.9 тэрбум төгрөг буюу сая батлагдсан төсвийнхөөс 1.4 тэрбум төгрөгөөр бага байх ёстой.

Дахин онцлоход бидний гол үндэслэл бол төсвийн зарлагыг огцом ихээр өсгөх нь эдийн засгийг хэт халааж, дэлхийн эдийн засгийн цочролд өртөмтгий болгож байна. Тэгээд бүр яг буруу цаг үед. Үүнтэй холбоотойгоор хэлэхгүй өнгөрч болохгүй зүйл гэвэл 2012 оны төсвийн зарлагын батлагдсан хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тогтоосон 2013 оноос бүрэн дүүрэн хэрэгжих ёстой тоон дүрмийг хангах асуудлыг бэрхшээлтэй болгож байна. Үнэндээ, 2013 оны төсвийн алдагдлын дүрмийг хангахад оны үнээр тооцсон зарлагыг хасах шаардлагатай болно. Инфляцын тохируулга хийсэн үнээр бол зарлагыг 10-15 хувиар танах ёстой. 2010-2012 онд төсвийн зарлагыг хоёр дахин өсгөчихөөд 2013 онд эргээд танана гэдэг нь эдийн засгийн хувьд ямар ч ач холбогдолгүй, эдийн засгийг галзуу хулгана тоглоомоор аялуулахтай адил болгож байна.

**-Монголбанкныхны хувьд инфляцыг арван хувьд барих боломжтой гэж үзэж байгаа ч улс төрийн намуудын өнгөрсөн сонгуулийн сая төгрөгийн амлалтын асуудалд санаа зовж байгаа. Засгийн газрын зүгээс ард иргэдэд нэг бол Тавантолгойн хувьцаа, эсвэл нэг сая төгрөгөө бэлнээр нь авах гэсэн сонголт өгчихөөд байна. Хэрэв олон хүн сая төгрөгөө бэлнээр нь авна гэвэл инфляцыг хөөрөгдөнө гэж байгаа. Энэ талаар таны бодол. Ямар зохицуулалт хийвэл зохилтой вэ?**

-Энэ нь үнийн хөөрөгдлийг дэвэргэхээс гадна эдийн засагт сөргөөр нөлөөлөх учраас маш их эрсдэлтэй гэсэн үг. Яагаад гэвэл дэлхийн эдийн засаг осолтой байдалд байна. Монгол Улсын хувьд энэ нь эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр огцом унах магадлал хэвийн үеийг бодвол хамаагүй өндөр болсон гэсэн үг. Энэ магадлал биеллээ олсон тохиолдолд Засгийн газар төсвийн алдагдлаа санхүүжүүлэх боломжгүй болж, төсвийн зарлагыг эрс танахаас өөр аргагүй болно. Энэ нь дэлхийн эдийн засгийн цочролын Монгол Улсын эдийн засагт үзүүлэх үр нөлөөг ихэсгэнэ. Мөн бидний яриад байдаг тэлэлт, агшилтын бодлогын тод илрэл болно.

**-Монголын эдийн засгийн хурдтай өсөлтийг дэлхий даяараа шагшиж, онцолж байна. Таны болон танай байгууллагынхны үзэж буйгаар энэ ер нь хэр бодитой өсөлт вэ. Жирийн ард иргэд, олонхийн амьдралд энэ их өсөлт бараг л мэдрэгдэхгүй байгаа. Бодитой хүртээхийн тулд яавал зохилтой вэ?**

-Эрдэс баялгийг зөв зохистой зарцуулж ашиглах нь Монгол Улсын иргэдэд хөгжил цэцэглэлт авчирч, “нөөцийн хараал”-аас зайлсхийхэд чухал ач холбогдолтой. Одоогоор үүнийг сайн хийж чадахгүй байна. Харин ч эсрэгээрээ цалин хөлсийг огцом нэмэгдүүлж, Монголын аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг доройтуулж байна. Мөн үнийн хөөрөгдлийг даамжруулж, бага орлоготой иргэдийн амьжиргааг дордуулж, аж ахуй эрхлэх боломж нөхцөлийг хүндрүүлж байна. Эцэст нь мөнгөний хатуу бодлого баримтлахаас өөр аргагүй байдлыг бий болгож, хувийн хэвшлийнхнийг шахан зайлуулж байна.

**-Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөвийн талаар таны бодлыг сонсьё. Энэ нь Монголын эдийн засагт хэр их сөргөөр нөлөөлөх бол. Ялангуяа дэлхийн түүхий эдийн зах зээлийн хэтийн төлөв ямаршуухан дүр зурагтай байх бол. Зэсийн үнэ буурсаар байна. Монголын эдийн засаг үүнд хариу үйлдэл үзүүлэх чадвартай байна уу?**

-Дээр дурдсанчлан дэлхийн эдийн засаг осолтой үе шатанд байна. Европт нүүрлэсэн Засгийн газрын өр зээлийн хямралаас үндсэндээ шалтгаалан төлөв байдал муудах эрсдэл нэлээд өндөр байна. Европын эдийн засагт томоохон уналт бий болсноор дэлхийн эдийн засгийн өсөлт, эрдэс баялгийн үнэд сөргөөр нөлөөлөх нь гарцаагүй.

Монгол Улсад өөрийгөө тусгаарлах, ийм төрлийн цочролоос хамгаалах чадвар байна. Үүний тулд одоо баримталж буй тэлэлт, агшилтын бодлогоос нэг мөр татгалзах хэрэгтэй. Тухайлбал, төсвийн зарлага бидний зөвлөж байгаа шиг үлэмж доогуур байсан бол дэлхийн зах зээл дээр үнэ унасан ч зарлагаа нэмэгдүүлэх боломж нээлттэй байх болно. Ингэснээр тухайн цочролын үр нөлөөг сааруулж болно. Гэтэл өнөөгийн байдал ямар байна вэ гэхээр эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ огцом унасан нөхцөлд төсвийн зарлагаа танахаас өөр аргагүй байдал үүснэ.

Болж байгаа зүйлийн тухайд харин уян хатан ханшийн тогтолцоо үр дүн сайтай байна. Энэ нь өнгөрсөн хямралтай харьцуулахад томоохон ялгаа бөгөөд сайн цочрол шингээгч болох учиртай. Иймд бид ханшийн өнөөгийн тогтолцоог бүрэн дэмжиж байгаа. Түүнээс гадна, гадаад валютын нөөц түүхэндээ байгаагүй өндөр хэмжээнд хүрч, бас нэг хамгаалалт болох нь гарцаагүй.

**-Нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд төсвийн тогтворжуулалтын сан ямар үүрэг гүйцэтгэж чадах вэ?**

-Энэ тохиолдолд төсвийн тогтворжуулалтын сан их хэрэгтэй байдаг. Гэхдээ санхүүгийн хөрөнгөтэй болохын тулд бодит байдал дээр төсвийн тэнцэл ашигтай гарах шаардлагатай. Гэтэл Монгол Улсын Засгийн газар энэ болон ирэх онд томоохон алдагдалтай төсөвтэй байгаа. Тэгэхээр 2011-2012 оны төсөв санхүүгийн хамгаалалт үүсгэхийн оронд эдийн засгийг илүү эмзэг болгож байна.

**-Монгол Улс уул уурхайгаас орж ирж буй баялгаа зөв зүйтэй зарцуулж чадвал богино хугацаанд хөгжинө гэж байгаа. Гэтэл хавтгайрсан халамж, инфляцын өсөлт, эдийн засгийн халалт гээд “Голланд өвчин”-ий шинж тэмдэг хэдийнэ илэрч эхэллээ гэж зарим нь яриад байгаа?**

-Төсвийн бодлогын өнөөгийн замнал нь “Голланд өвчин”, баялгийн хараал руу шууд чиглэж байгааг харахад харамсалтай байна. Инфляц хэт өндөр болж, нэн ялангуяа суурь инфляцын үзүүлэлтийг харвал цаашид өсөх хандлагатай байна. Он гарснаас хойш суурь инфляцын хурдац ихэнхдээ хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэж байсан. Сүүлийн саруудад бүр нэмэгдсэн. Төрийн албан хаагчдын цалин хөлсийг өнгөрсөн онд 35 хувиар өсгөсөн, ирэх онд дахин 50 гаруй хувиар нэмэх гэж байна. Энэ нь Монгол Улсын өрсөлдөх чадварыг сулруулж, аж ахуй эрхлэх өртгийг нэмэгдүүлнэ.

Иргэн бүрт олгож байгаа бэлэн мөнгөний тухайд, зорилтот бүлэгт чиглэсэн ядуурлын тэтгэмжийг нэвтрүүлснээр ядуурлыг бууруулах илүү үр дүнтэй арга болохын зэрэгцээ төсвийн хөрөнгийг хэмнэх боломж бүрдэнэ. Энэ утгаараа 2012 оны төсөвт ядуурлын тэтгэмжийг багтаасныг сайшааж, холбогдох хууль тогтоомжийг удахгүй баталж гаргана гэж найдаж байна.

**-Таны бодлоор уул уурхайдаа түшиглэн хөгжсөн орнуудын Монголд хамгийн ойр, хэрэг болохуйц жишээг дурдвал?**

-Сайн жишээ гэвэл Норвеги, Чили улсууд юм. Чили нь Монгол Улсыг бодвол илүү хөгжсөн ч гэсэн маш сайн жишээ бөгөөд өнгөрсөн онд УИХ-аас баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь Чилийн тогтолцооны нэлээд хэсгийг өөртөө багтаасан байгаа. Одоо хамгийн гол нь энэ хуулийн үг үсэг, үзэл санааг яс баримтлахад оршиж байна. Үүнтэй холбоотой өөр нэг зүйл бол Хөгжлийн банкны үйл ажиллагааны талаар бид маш их санаа зовж байна. Учир нь, уг банкныг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тогтоосон тоон дүрмийг тойрч гарах арга хэрэгсэл болгож ашиглах эрсдэл байна.

**-Таны бодлоор Монголд уул уурхайгаас өөр хөгжлийн гарц болох ямар, ямар салбар, боломжууд байж болох вэ?**

-Макро эдийн засагч хүний хувьд хувийн хэвшлийн өсөлтийг дэмжсэн орчин бүрдүүлэхийн ач холбогдлыг онцлохыг хүсч байна. Өөрөөр хэлбэл нам төвшний инфляц бүхий эдийн засгийн эрүүл саруул, тогтвортой өсөлт байх ёстой. Үүний тулд яах вэ. Хамгийн гол нь төсвийн ухаалаг бодлого нь мөчлөг сөрсөн байж, эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийн савлагаанаас шалтгаалан эдийн засгийн өсөлтөд гарч буй өөрчлөлтүүдийг намжаан зөөлрүүлэхэд тус болох, мөнгөний бодлого инфляцыг хазаарлахад чиглэсэн байх, уян хатан ханшийн тогтолцооны тусламжтайгаар цочролыг шингээж, эдийн засгийн урт хугацаанд зохицон өөрчлөгдөх нөхцөлийг бүрдүүлэх ёстой.